



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 27 өдөр

Дугаар IV/33

Мөрөн сум

┌ Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот ┐
үйлдвэрийн газрыг татан буулгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12, 48 дугаар зүйлийн 48.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4, “Хөвсгөл аймгийн Залуучууд хөгжлийн төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 17.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IV хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл аймгийн Залуучууд хөгжлийн төв” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (цаашид ААТҮГ гэх)-ын үйл ажиллагааг 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгасугай.

2. Орон нутгийн өмчит ААТҮГ-ыг татан буулгахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.


3. “Хөвсгөл аймгийн Залуучууд хөгжлийн төв” ААТҮГ-ын хаалтын тайланг татан буулгасан өдрөөр гарган, авлага, өглөгийг тооцоо нийлэн баталгаажуулж, аймгийн Биеийн тамир спортын газарт шилжүүлэх, компанид бүртгэлтэй эд хөрөнгийг хүлээлгэн өгөх, хүлээн авах, татан буугдаж байгаа тухай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлах, компанид хөтлөгдсөн баримт бичгийг байгууллагын архивын ажлын үндсэн зааврын дагуу хадгаламжийн нэгж бүрдүүлэн аймгийн Архивын тасагт хүлээлгэн өгөхийг “Хөвсгөл аймгийн Залуучууд хөгжлийн төв” ААТҮГ-ын гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Пүрэвсүрэн), ажлын хэсгийн ахлагч (Д.Цэцэгмаа) нарт даалгасугай.

4. Татан буулгахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулж, тайланг 2025 оны II улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд ирүүлэхийг ажлын хэсэг (Д.Цэцэгмаа)-д, тогтоолын биелэлтэд хяналт

тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Бэхбаяр)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 06 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ПҮРЭВДОРЖ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2025 оны 01 дүгээр сарын
17-ны өдрийн ээлжит IV хуралдааны
32- дугаар тогтоолын хавсралт

PHOA0003 9670591

ХӨВСГӨЛ АЙМГИЙН “ЗАЛУУЧУУД ХӨГЖЛИЙН ТӨВ”
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫГ
ТАТАН БУУЛГАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Цэцэгмаа (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн дарга)

Гишүүд:

Л.Батцэцэг (Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)

Б.Бат-Оргил (аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль, эрх зүйн
хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Л.Батжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн
хэлтсийн төсвийн ерөнхий нягтлан бодогч)

Б.Пүрэвсүрэн (Хөвсгөл аймгийн “Залуучууд хөгжлийн төв”) ААТҮГ-ын
гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Г.Нандин-Эрдэнэ (Хөвсгөл аймгийн “Залуучууд хөгжлийн төв”) ААТҮГ-ын
нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга:

Ц.Бэхбаяр (аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч)